

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2012 ОНЫ ШҮҮН
ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮНГИЙН
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2013 оны 01 дүгээр
сарын 18-ний өдөр

Улаанбаатар
хот

Нэг. Эрүүгийн шүүн таслах ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд 2012 онд 10672 хүнд холбогдох 7065 эрүүгийн хэрэг хүлээн авч, 851 хүнд холбогдох 472 эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, 20 хүнд холбогдох 12 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, шүүгдэгч, хохирогч эвлэрснээр 522 хүнд, цагаатгах тогтоолоор 219 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, **8324** хүнд холбогдох **6161** хэргийг таслан шийдвэрлэж, 736 холбогдогчтой 420 хэргийн үлдэгдэлтэй байна.

Өнгөрсөн оноос шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 4,8 хувиар, ял шийтгүүлэгчид 1,4 хувиар өсчээ.

Анхан шатны шүүхээр 2012 онд таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, ял шийтгүүлэгчдийг өмнөх онтой нь харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Эрүүгийн хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2011 он	2012 он	тоо	хувь	2011 он	2012 он	тоо	хувь
1	Архангай	108	143	35	32.4	204	208	4	2.0
2	Баян-Өлгий	88	101	13	14.8	132	131	-1	-0.8
3	Баянхонгор	170	132	-38	-22.4	199	190	-9	-4.5
4	Булган	124	118	-6	-4.8	164	167	3	1.8
5	Говь-Алтай	84	84	0	0.0	118	130	12	10.2
6	Говьсүмбэр	33	37	4	12.1	48	48	0	0.0
7	Дархан-Уул	278	229	-49	-17.6	412	295	-117	-28.4
8	Дорнод	120	118	-2	-1.7	162	160	-2	-1.2
9	Дорноговь	179	175	-4	-2.2	235	220	-15	-6.4
10	Дундговь	80	80	0	0.0	83	106	23	27.7
11	Завхан	52	82	30	57.7	63	123	60	95.2
12	Орхон	161	167	6	3.7	267	242	-25	-9.4
13	Өвөрхангай	182	194	12	6.6	266	276	10	3.8
14	Өмнөговь	128	144	16	12.5	172	177	5	2.9
15	Сүхбаатар	110	90	-20	-18.2	102	99	-3	-2.9
16	Сэлэнгэ	279	337	58	20.8	409	472	63	15.4
17	Төв	213	245	32	15.0	291	341	50	17.2
18	Увс	125	117	-8	-6.4	200	182	-18	-9.0
19	Ховд	114	78	-36	-31.6	151	115	-36	-23.8
20	Хөвсгөл	185	195	10	5.4	250	243	-7	-2.8
21	Хэнтий	265	201	-64	-24.2	338	286	-52	-15.4
22	Нийслэл	2799	3094	295	10.5	3944	4113	169	4.3
	Дүн	5877	6161	284	4.8	8210	8324	114	1.4

байдалтай байна.

Таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг Дорнод, Дорноговь, Булган, Увс, Дархан-Уул, Сүхбаатар, Баянхонгор, Хэнтий, Ховд аймагт 1,7 – 31,6 хувиар буурч, Орхон, Хөвсгөл, Өвөрхангай, Нийслэл, Говьсүмбэр, Өмнөговь, Баян-Өлгий, Төв, Сэлэнгэ, Архангай, Завхан аймагт 3,7 – 57,7 хувиар нэмэгджээ. Харин Говь-Алтай, Дундговь аймгууд өмнөх оны мөн үетэй адил байна.

Ял шийтгүүлэгчид Баян-Өлгий, Дорнод, Хөвсгөл, Сүхбаатар, Баянхонгор, Дорноговь, Увс, Орхон, Хэнтий, Ховд, Дархан-Уул аймагт 0,8 – 28,4 хувиар буурч, Булган, Архангай, Өмнөговь, Өвөрхангай, Нийслэл, Говь-Алтай, Сэлэнгэ, Төв, Дундговь, Завхан аймагт 1,8 – 95,2 хувиар өссөн байна. Мөн Говь-Сүмбэр аймаг өмнөх оны мөн үетэй адил байна.

Анхаарал татаж байгаа эрүүгийн хэргийг авч үзвэл:

Д/д	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчид			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2011 он	2012 он	тоо	хувь	2011 он	2012 он	тоо	хувь
1	Хүнийг санаатай алах	242	259	17	7.0	269	262	-7	-2.6
2	Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах	290	287	-3	-1.0	294	288	-6	-2.0
3	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	1282	1281	-1	-0.1	2227	2191	-36	-1.6
4	Танхайрах	863	819	-44	-5.1	1327	1172	-155	-11.7
5	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	222	223	1	0.5	437	464	27	6.2
6	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	865	966	101	11.7	888	966	78	8.8
7	Албан тушаалын гэмт хэрэг	22	16	-6	-27.3	33	36	3	9.1
8	Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	35	37	2	5.7	54	77	23	42.6

байдалтай байна.

Эдгээр төрлийн гэмт хэрэг таслан шийдвэрлэсэн нийт хэргийн 63,1 хувь, ял шийтгүүлэгчдийн 65,5 хувийг эзэлж байгаа бол бусдын эд хөрөнгийг хулгайлах, танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн нийлбэр нь нийт хэргийн 49,8, ял шийтгүүлэгчдийн 52,0 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн оныхоос бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 0,1, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 1,0, танхайрах гэмт хэрэг 5,1, албан тушаалын гэмт хэрэг 27,3 хувиар буурсан бол, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 0,5, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 5,7, хүнийг санаатай алах гэмт хэрэг 7,0, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 11,7 хувиар тус тус өсчээ.

Ял шийтгүүлэгчдийн байдлыг авч үзвэл:

Д/д	Үзүүлэлт	Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2011 он	2012 он	Тоо	Хувиар
Ял шийтгүүлэгчид, Үүнээс:	Насанд хүрээгүй этгээд	542	570	28	5.2
	Эмэгтэйчүүд	724	726	2	0.3
	Гадаадын харъяат	27	39	12	44.4
	Урьд ял шийтгүүлсэн	1460	1544	84	5.8
	Гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн	1465	1498	33	2.3
	Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн	1704	1717	13	0.8
	Ажил, сургуульгүй хүмүүс	5493	5471	-22	-0.4

байдалтай байна.

Гэмт хэргийн улмаас нийтдээ 21 тэрбум 982 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирч, 654 хүний амь хохирч, 2963 хүний биед (хүнд, хүндэвтэр, хөнгөн) гэмтэл учирчээ.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдлыг авч үзвэл:

Д/д	Төрөл	Бүтэн жил		Нийт ялын дотор эзлэх хувь	
		2011 он	2012 он	2011 он	2012 он
Нийт ял шийтгүүлэгчид		8210	8324		
1	<i>Хорих ялаар бүгд: Үүнээс</i>	6357	6457	77.4	77.6
	а/ Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	2781	2691		
	б/ Тэнссэн	3084	3217		
	в/ Эрүүгийн хуулийн 62, 63-р зүйлээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан Үүнээс:	442	480		
	а/Насанд хүрээгүй этгээд	362	382		
	б/Жирэмсэн эмэгтэй 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг	80	98		
	г/ Өршөөл үзүүлсэн	50	69		
2	<i>Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн: Үүнээс</i>	1770	1728	21.6	20.7
	а/ Торгох ял	271	272		
	б/ Албадан ажил хийлгэх ял	476	482		
	в/ Баривчлах ял	1023	974		
3	<i>Бусад ял</i>	10	7	0.1	0.1
4	<i>Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ</i>	63	132	0.9	1.6

байдалтай байна.

Ял шийтгүүлэгчдийн 77,6 хувьд хорих, 5,8 хувьд албадан ажил хийлгэх, 11,7 хувьд баривчлах, 0,1 хувьд бусад ял оногдуулж, насанд хүрээгүй 132 этгээдэд (1,6 хувь) хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авчээ. Мөн 3,2 хувь буюу 272 хүнийг 1 тэрбум 317 сая төгрөгөөр торгох ял оногдуулжээ.

2691 хүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлсэн нь хорих ял шийтгүүлэгчдийн 41,7 хувь нь болж байна.

Хорих ялыг биечлэн эдлүүлсэн ба баривчлах ялаар шийтгүүлсэн хүн 3665 байгаа нь нийт ял шийтгүүлэгчдийн 44.0 хувийг эзэлж байна.

Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг 478 хүнд хэрэглэж 193,8 сая төгрөг гаргуулсны дээр, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 677 хүнд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулжээ.

Шүүх хорих ял биечлэн эдлүүлсэн 2691 хүний 69,3 хувийг жирийн, 29,5 хувийг чанга, 1,0 хувийг онцгой, 0,2 хувийг гяндангийн дэглэмд ял эдлүүлэхээр тогтоожээ.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар эрүүгийн 2275 хэрэг хүлээн авснаас 2168 хэргийг хянан шийдвэрлэж, 1130 буюу 52,1 хувьд нь захирамж, тогтоолыг хэвээр үлдээж, 515 буюу 23,8 хувьд нь захирамж, тогтоолд өөрчлөлт оруулж, 523 буюу 24,1 хувьд нь захирамж, тогтоолыг хүчингүй болгожээ. Оны эцэст 55 хэргийн үлдэгдэлтэй гарав. 52 хэргийн хувьд эрх бүхий этгээд гаргасан гомдол, эсэргүүцлээсээ татгалзан буцаан авчээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2011 он	2012 он	2011 он	2012 он	зөрүү +/-,-/-
Хянан шийдвэрлэсэн бүгд	2032	2168			
Хэвээр үлдээсэн	1080	1130	53,1	52,1	-1,0
Өөрчлөлт оруулсан	444	515	21,9	23,8	+1,9
Хүчингүй болгосон	508	523	25,0	24,1	-0,9
Үлдэгдэл	94	55			

Давж заалдах шатны шүүх 1038 тогтоолыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 47,9 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар эрүүгийн 1049 хэрэг хүлээн авснаас 859 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсний 370 нь прокурорын дүгнэлтээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг шийдвэрлэсэн хэрэг байна. Үүний 355 нь цагаатгалын хэрэг. Нийт 859 хэргийг хянаж, хариу өгсөн ба оны эцэст 40 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоол, магадлалын 322 буюу 37,5 хувийг хэвээр үлдээж, 88 буюу 10,2 хувийг өөрчилж, 449 буюу 52,3 хувийг хүчингүй болгожээ.

		Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
		2011 он	2012 он	2011 он	2012 он	зөрүү /+/, -/
Хүлээн авсан хэрэг		822	1049			
Хянаад хариу өгсөн хэрэг		105	150			
Нийт шийдвэрлэсэн хэрэг		704	859			
Үүнээс:	Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	3	2			
	Хяналтын шатын шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	701	487			
	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн	259	370			
Хэвээр үлдээсэн		252	322	35,8	37,5	+1,7
Өөрчлөлт оруулсан		90	88	12,8	10,2	-2,6
Хүчингүй болгосон		362	449	51,4	52,3	+0,9
Үлдэгдэл		13	40			

Хяналтын шатны шүүх 537 тогтоол, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 62,5 хувийг эзэлж байна.

Хоёр. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд 39690 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авч, 8131 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, бүгд **27792** хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 2576 хэргээр буюу 8,5 хувиар буурсан байна. Оны эцэст 3767 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Хянан шийдвэрлэсэн нийт 27792 хэргийн 10852 буюу 39,0 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 16388 буюу хувийг 59,0 шүүх хуралдаанаар хянан хэлэлцжээ. /552 хэрэг буюу 2,0 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлд зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгосон байна./

Анхан шатны шүүхээр 2012 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг урьд онтой харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд		өсөлт, бууралт	
		2011 он	2012 он	тоо	хувь
1	Архангай	636	554	-82	-12.9
2	Баян-Өлгий	671	616	-55	-8.2
3	Баянхонгор	595	625	30	5.0
4	Булган	507	403	-104	-20.5
5	Говь-Алтай	319	264	-55	-17.2
6	Говьсүмбэр	153	146	-7	-4.6
7	Дархан-Уул	1634	1150	-484	-29.6
8	Дорнод	889	898	9	1.0
9	Дорноговь	464	463	-1	-0.2
10	Дундговь	421	388	-33	-7.8
11	Завхан	665	610	-55	-8.3
12	Орхон	1196	974	-222	-18.6
13	Өвөрхангай	1066	923	-143	-13.4
14	Өмнөговь	452	405	-47	-10.4
15	Сүхбаатар	348	310	-38	-10.9
16	Сэлэнгэ	1426	1056	-370	-25.9
17	Төв	1494	1423	-71	-4.8
18	Увс	687	592	-95	-13.8
19	Ховд	1172	770	-402	-34.3
20	Хөвсгөл	1423	1151	-272	-19.1
21	Хэнтий	782	542	-240	-30.7
22	Нийслэл	13368	13529	161	1.2
	Дүн	30368	27792	-2576	-8.5

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг Дорнод, Нийслэл, Баянхонгор аймагт 0,1 – 5,0 хувиар нэмэгджээ. Харин Дорноговь, Говьсүмбэр, Төв, Дундговь, Баян-Өлгий, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Архангай, Өвөрхангай, Увс, Говь-Алтай, Орхон, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий, Ховд аймагт 0,2 – 34,3 хувиар буурчээ.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү /+,/-/
	2011 он	2012 он	2011 он	2012 он	
Нийт иргэний хэрэг	30368	27792			
Иргэний эрх зүйн маргаан	11568	11796	38,1	42,4	+4,3
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар	11152	9262	36,7	33,3	-3,4
Гэр бүлийн эрх зүйн маргаан	4449	3878	14,7	14,0	-0,7
Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	897	742	2,9	2,7	-0,2
Бусад эрх зүйн маргаан: Үүнээс:	2302	2114	7,6	7,6	-
Газрын тухай хуулиар	101	142			
Дампуурлын тухай хуулиар	7	37			
Компанийн тухай хуулиар	24	16			
Нийгмийн даатгалын багц хуулиар	128	97			
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар	210	147			
Татварын ерөнхий хуулиар	283	251			
Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	5	2			
Төрийн албаны тухай хуулиар	6	4			
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулиар	70	73			
Бусад хуулиар	1468	1345			

Нийт хэрэгт иргэний эрх зүйн маргаан 42,4, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн маргаан 33,3, гэр бүлийн эрх зүйн маргаан 14,0, хөдөлмөрийн эрх зүйн маргаан 2,7 хувийг тус тус эзэлж байна.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар 1748 хэрэг хүлээн авснаас 1650 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс 857 буюу 51,9 хувьд нь шийдвэрийг хэвээр үлдээж, 394 буюу 23,9 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 399 буюу 24,2 хувьд шийдвэрийг хүчингүй болгож, оны эцэст 48 хэргийн үлдэгдэлтэй гарав.25 хэргийн хувьд давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзаж, 25 хэрэг нь эрх бүхий этгээд гаргасан гомдол, эсэргүүцлээсээ татгалзан буцаан авчээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2011 он	2012 он	2011 он	2012 он	зөрүү /+/,/-/
Хянан шийдвэрлэсэн бүгд	1830	1650			
Хэвээр үлдээсэн	989	857	54,0	51,9	-2,1
Өөрчлөлт оруулсан	448	394	24,5	23,9	-0,6
Хүчингүй болгосон	393	399	21,5	24,2	+2,7
Үлдэгдэл	53	48			

Давж заалдах шатны шүүх 793 шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 48,1 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар иргэний 981 хэрэг хүлээн авч, 177-г хянан хариу өгч, 778 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн байна. Үүнээс шийдвэр, магадлалын 473 буюу 60,8 хувийг хэвээр үлдээж, 158 буюу 20,3 хувийг өөрчилж, 147 буюу 18,9 хувийг нь хүчингүй болгож, 26 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хянан шийдвэрлэсэн нийт 778 хэргээс 1 хэргийг Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар, 24 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ.

		Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
		2011 он	2012 он	2011 он	2012 он	зөрүү /+/,/-/
	Хүлээн авсан хэрэг	1135	981			
	Хянаад хариу өгсөн хэрэг	228	177			
	Нийт шийдвэрлэсэн хэрэг	861	778			
Үүнээс:	Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	1	1			
	Хяналтын шатын шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	822	753			
	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн	38	24			
	Хэвээр үлдээсэн	579	473	67,2	60,8	-6,4
	Өөрчлөлт оруулсан	173	158	20,1	20,3	+0,2
	Хүчингүй болгосон	109	147	12,7	18,9	+6,2
	Үлдэгдэл	46	26			

Хяналтын шатны шүүх 305 шийдвэр, магадлалыг өөрчилж хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 39,2 хувийг эзэлж байна.

Гурав. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Захиргааны хэргийн шүүхүүд 2012 онд 1740 нэхэмжлэл, гомдол хүлээн авч, 438 нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх буюу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаар нэхэмжлэгчид нь буцааж, **961** хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 70 хэргээр буюу 7,9 хувиар өсчээ.

Оны эцэст 341 хэргийн үлдэгдэлтэй гарсны дотор хуульд заасан үндэслэлээр 47 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, 70 хэргийн шүүх хуралдааныг хойшлуулж, 224 хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

2012 онд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг шүүх тус бүрээр үзүүлбэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2011 он	2012 он	тоо	хувь
1	Архангай	18	16	-2	-11.1
2	Баян-Өлгий	46	51	5	10.9
3	Баянхонгор	12	14	2	16.7
4	Булган	18	26	8	44.4
5	Говь-Алтай	5	13	8	1.6 дахин
6	Говьсүмбэр	5	8	3	60.0
7	Дархан-Уул	27	18	-9	-33.3
8	Дорнод	14	16	2	14.3
9	Дорноговь	24	9	-15	-62.5
10	Дундговь	8	9	1	12.5
11	Завхан	1	13	12	1.2 дахин
12	Орхон	38	29	-9	-23.7
13	Өвөрхангай	22	22	0	0.0
14	Өмнөговь	11	5	-6	-54.5
15	Сүхбаатар	21	17	-4	-19.0
16	Сэлэнгэ	8	33	25	3 дахин
17	Төв	11	18	7	63.6
18	Увс	32	25	-7	-21.9
19	Ховд	10	15	5	50.0
20	Хөвсгөл	19	55	36	1.9 дахин
21	Хэнтий	8	8	0	0.0
22	Нийслэл	533	541	8	1.5
	Дүн	891	961	70	7.9

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг Нийслэл, Баян-Өлгий, Дундговь, Дорнод, Баянхонгор, Булган, Ховд, Говьсүмбэр, Төв, Говь-Алтай, Хөвсгөл, Сэлэнгэ, Завхан аймагт 1,5 хувиас 3 дахин нэмэгдэж, Архангай, Сүхбаатар, Увс, Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь аймагт 11,1 – 62,5 хувиар буурчээ. Харин Өвөрхангай, Хэнтий аймгуудад өмнөх оны мөн үетэй адил байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг маргааны төрлөөр авч үзвэл,

Маргааны төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь	
	2011 он	2012 он	2011 он	2012 он
Нийт захиргааны хэрэг	891	961		
Сонгуультай холбоотой маргаан	10	120	1,1	12,5
Төрийн албаны тухай хуулиар	139	133	15,6	13,8
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан	11	18	1,2	1,9
Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан	83	80	9,3	8,3
Газрын маргаан	228	210	25,6	21,9
Ашигт малтмалтай холбоотой маргаан	86	119	9,7	12,4
Татварын маргаан	76	73	8,5	7,6
Тендерийн маргаан	38	42	4,3	4,4
Бусад маргаан	220	166	24,7	17,2

байдалтай байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 557 хэрэг хүлээн авч, 499 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэнээс, 2 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ. Хянан хэлэлцсэн нийт хэргийн 48,9 хувь буюу 244 шийдвэр, захирамжийг хэвээр үлдээж, 26,1 хувь буюу 130 шийдвэрт өөрчлөлт оруулж, 25,0 хувь буюу 125 шийдвэр захирамжийг хүчингүй болгож, оны эцэст 40 хэргийн үлдэгдэлтэй гарчээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь			
	2011 он	2012 он	2011 он	2012 он	зөрүү /+/, -/	
Хүлээн авсан хэрэг	551	557				
Хянаад хариу өгсөн	12	18				
Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс:	492	499				
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	484	497				
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	8	2				
Үүнээс	Хэвээр үлдээсэн	265	244	53,9	48,9	-5,0
	Өөрчлөлт оруулсан	66	130	13,4	26,1	+12,7
	Хүчингүй болгосон	161	125	32,7	25,0	-7,7
Үлдэгдэл	47	40				

Хяналтын шатны шүүх 281 хэрэг хүлээн авснаас 220 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 47 хэргийг хянан хариу өгч, одоо 14 хэргийн үлдэгдэлтэй байна. Хянан хэлэлцсэн 220 хэргээс 8 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн 220 хэргийн 63,6 хувь буюу 140 шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, 25,0 хувь буюу 55 шийдвэр, магадлалыг өөрчилж, 11,4 хувь буюу 25 шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.

Үзүүлэлт		Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
		2011 он	2012 он	2011 он	2012 он	зөрүү +/-,-/-
Хүлээн авсан хэрэг		331	281			
Хянаад хариу өгсөн хэрэг		70	47			
Нийт шийдвэрлэсэн хэрэг. Үүнээс:		240	220			
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг		228	212			
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан		12	8			
Үүнээс	Хэвээр үлдээсэн	171	140	71,2	63,6	-7,6
	Өөрчлөлт оруулсан	47	55	19,6	25,0	+5,4
	Хүчингүй болгосон	22	25	9,2	11,4	+2,2
Үлдэгдэл		9	14			

Хяналтын шатны шүүх 80 шийдвэр, магадлалыг өөрчилж хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 36,4 хувийг эзэлж байна.

Дөрөв. Бусад асуудлаар

Анхан шатны шүүхүүд бүгд 14722 (+1270) хүнд захиргааны арга хэмжээ авсны дотор 727 (+52) хүнийг 33,0 (+23,6) сая төгрөгөөр торгож, 13995 (+1218) хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ.

Захиргааны зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгчийн гаргасан гомдлоор захиргааны шийтгэл ногдуулсан 312 (+104) шийтгэврийг давж заалдах журмаар хянаснаас 220 буюу 71,2 хувьд хэвээр үлдээж, 73 буюу 23,4 хувьд өөрчлөлт оруулж, 17 буюу 5,4 хувийг хүчингүй болгожээ.

Тайлангийн хугацаанд шүүхүүд ялтныг хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах тухай 809 (-665) материалыг хянан хэлэлцэж, 27 (-9) санал дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож, 1289 (+394) хоригдлыг эдлээгүй үлдсэн хорих ялаас нь тэнсэн суллаж, 492 (+460) хоригдлын хорих ялыг хорихоос өөр төрлийн хөнгөн ялаар сольж, 95 (-416) хоригдлын ял эдлэх дэглэмийг өөрчилжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 837 (+122) сэжигтнийг баривчлах тухай материалыг хүлээн авч, 793 (+114) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 44 (+8) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 2398 (+176) хүнийг сэжигтнээр, 1940 (-233) хүнийг яллагдагчаар цагдан хорьж, 243 (-62) хүнд цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

Иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад улсын тэмдэгтийн хураамжид 3 тэрбум 570,9 (+1153,3) сая төгрөг, үүнээс анхан шатны шүүх 3 тэрбум 53,5 (+1100,5) сая төгрөг, давж заалдах шатны шүүх 332,1 (-0,2) сая төгрөг, хяналтын шатны шүүх 185,3 (+53,1) сая төгрөгийг улс, орон нутгийн орлогод оруулахаар шийдвэрлэв. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр анхан шатны шүүхээс 388,3 (-21,8) сая төгрөг, давж заалдах шатны шүүхээс 194,9 (+50,9) сая төгрөг, хяналтын шатны шүүхээс 82,9 (-9,6) сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг зохигчдод буцаан олгохоор шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхүүд нийт 66819 (-887) хэрэг, маргааныг шийдвэрлэсний дотор эрүүгийн 6645 (+307), иргэний 35923 (-3095), захиргааны 1399 (+105) хэрэг, 14722(+1270) захиргааны зөрчил, ялтныг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай 2712 (+1238) хүсэлт, 5418 (-712) хүнд баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох эсэх тухай асуудал хэлэлцжээ.

Ерөнхий харъяаллын анхан шатны шүүх болох сум, сум дундын шүүхийн нэг шүүгч дунджаар 193, дүүргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 338 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн байна.

Аймгийн Захиргааны хэргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 12, нийслэлийн захиргааны хэргийн нэг шүүгч дунджаар 103 хэрэг хянан шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхүүд эрүүгийн 2168, иргэний 1650, захиргааны 499, захиргааны зөрчлийн 312 бүгд 4629 хэрэг хянан шийдвэрлэжээ. Аймгийн шүүхийн нэг шүүгч дунджаар 26, нийслэлийн шүүхийн нэг шүүгч дунджаар 115, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч дунджаар 71 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүх буюу Улсын Дээд шүүх иргэний 778, эрүүгийн 857, захиргааны 220, нийтдээ 1855 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Дээд шүүхийн нэг шүүгчид дунджаар иргэний хэрэг 156, эрүүгийн хэрэг 171, захиргааны 44 хэрэг ногдож байна.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ